



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/1410

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг боловсролын салбарын мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг хамруулан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: Г.Чинбат (аймгийн Засаг даргын орлогч)
 Гишүүд: Л.Ариунтуяа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, төрийн бус байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн)
 О.Мөнхбаатар (Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)
 Н.Гэрэлтуяа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)
 Ц.Бадамгэрэл (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)
 Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын галын хяналтын улсын байцаагч)
 Нарийн бичгийн дарга: Ш.Жаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн)

2.Улсын үзлэгийг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж, тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг ажлын хэсэг (Г.Чинбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР